Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалллын сайдын 2026 оны 9 дугаар сарын 15-ны өдрийн А/176 тоот тушаалын арван гуравдугаар хавсралт

АМРАЛТ, СУВИЛАЛ, ЗОЧИД БУУДАЛ, САУН МАССАЖНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЧНЫ ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ ХЯНАЛТЫН ХУУДАС

А. Ерөнхий мэдээлэл

Хуулийн этгээдийн нэр, РД: .....
Үйл ажиллагааны чиглэл: .....
Хаяг, байршил: .....
Огноо: .....

Б. Орчны аюулгүй байдлын эрсдэл

№	Үнэлэх шалгуур үзүүлэлт	**Тийм** *(1)*	**Үгүй** *(0)*	Илэрсэн эрсдэл/Тайлбар
1.	Байгууллагын дотоод/гадаад орчинд ухсан нүх, суваг, шуудуу, траншей, цооног, ил цахилгааны утас, монтажийг засварлаагүй, аюултай	[ ]	[ ]	
2.	Өндөр хүчдэл, цахилгаан тоноглолд ойрхон	[ ]	[ ]	
3.	Газардуулга, хамгаалалтын төхөөрөмжийн доголдолтой	[ ]	[ ]	
4.	Гал унтраагуур, галын дохиололгүй/ажилладаггүй, галын гарц, аврах зам хаалттай	[ ]	[ ]	
5.	Шат, цонхны хаалт, хамгаалалт байхгүй, санамж байршуулаагүй, хүүхэд өндрөөс унах эрсдэлтэй	[ ]	[ ]	
6.	Хүүхдийн тоглоом хэрэгсэл, тоглоомын талбайн аюулгүй байдлыг шалгаж, эрсдэлийг арилгаагүй	[ ]	[ ]	
7.	Ариун цэврийн байгууламжийн шаардлага хангагдаагүй	[ ]	[ ]	
8.	Гар угаах, ариутгах нөхцөл дутмаг	[ ]	[ ]	
9.	Хог хаягдал, орчны бохирдол ихтэй	[ ]	[ ]	
10.	Орчны гэрэлтүүлэг хангалтгүй, харанхуй	[ ]	[ ]	
11.	Явган зам, гарц эвдрэлтэй, тэмдэг тэмдэглэгээгүй, авто замтай ойр байрладаг	[ ]	[ ]	
12.	Барилгын орц гарц нь босгогүй, үүдний хэсэгт халтиргаа, гулгаа үүсэхээс хамгаалсан шалавч, цардсан зам, тэргэнцрийн зориулалтын зам байхгүй			
13.	Цахилгаан, цэвэр усны хангамж байхгүй	[ ]	[ ]	
14.	Байгууллагын гадна орчин бүрэн камергүй, камерын бичлэгийг 30 ба түүнээс дээш хоног хадгалдаггүй	[ ]	[ ]	

15.	Ахуйн химийн бодис, эм эмийн хэрэгслийг цоожилж хадгалаагүй	[ ]	[ ]	
16.	Хоолны хордлого гарах эрсдэлтэй	[ ]	[ ]	
17.	Ундны усны чанар муу	[ ]	[ ]	
18.	Усан бассейн, рашаан сувиллын эрүүл ахуйн стандарт хангагдаагүй, халдварт өвчин тархах эрсдэлтэй	[ ]	[ ]	
19.	Агааржуулалт ажилладаггүй	[ ]	[ ]	
	Дүн			

Эрсдэлийн үнэлгээ: [>=50%] Их, [30%-49%] Дунд, [<=29%] Бага эрсдэлтэй гэж үзнэ.

Тайлбар: Хоолны хордлого гарах, ундны усны чанар муу байх, халдварт өвчин тархах эрсдэлийг ажиглалтаар үнэлэхдээ “Эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ыг уншиж, ашиглаарай.

В. Хүүхэд хамгааллын эрсдэл

№	Үнэлэх шалгуур үзүүлэлт	**Тийм** *(1)*	**Үгүй** *(0)*	Илэрсэн эрсдэл/Тайлбар
1.	Амралт, сувилал, зочид буудал, саун массажны байгууллагад хүүхдийн эсрэг хүчирхийлэл гардаг/гарах эрсдэлтэй ☐ Үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхалт гардаг эсэхийг мэдээлэх ☐ хүүхдийг үл хайхрах ☐ бие махбодын хүчирхийлэл ☐ сэтгэл санааны хүчирхийлэл ☐ бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт	[ ]	[ ]	
2.	Хүүхдийн эрхийн зөрчил, ялгаварлан гадуурхалт, цахим орчны хор нөлөөнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөгүй	[ ]	[ ]	
3.	Ажилтнууд болон амрагч, үйлчлүүлэгчдэд хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах үйлдлээс урьдчилан сэргийлэх, заавар, зөвлөмж өгдөггүй	[ ]	[ ]	
4.	Бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихыг хориглосон заавар, зөвлөмж байхгүй	[ ]	[ ]	
5.	Хүүхдийн хөдөлмөрийг хориглож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилладаггүй ☐ салбарын хууль, дүрэм, журам, стандартад **“хүүхдийн хөдөлмөрийг хориглосон заалт**” тусган батлаагүй ☐ байгууллага, аж ахуйн нэгжтэй байгуулах гэрээнд хүүхдийг хөдөлмөрийн хориглосон заалт тусгаж, мөрдүүлдэггүй	[ ]	[ ]	
6.	Байгууллагын Wi-Fi болон цахим сүлжээнд хүүхдийн насны ангилалд (18+) тохиргоогүй, хориотой контент руу	[ ]	[ ]	

	нэвтрэхээс хамгаалсан шүүлтүүр (content filtering) идэвхжүүлж, хяналт тавиагүй			
7.	Хүүхэд хамгааллын бодлого баталж, мөрдөөгүй	[ ]	[ ]	
8.	“Эрсдэлийн хяналтын хороо” байгуулаагүй	[ ]	[ ]	
9.	Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг таних, илрүүлэх, мэдээлэх заавар, журам байхгүй	[ ]	[ ]	
10.	Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй	[ ]	[ ]	
11.	Хүүхэд хөхүүлэх, хуурайлах амралтын өрөө байхгүй	[ ]	[ ]	
12.	Тусгай дугаарын 108, 102, 107 утасны мэдээлэл, санамж сурталчилгааг ил харагдах орчинд байршуулж, хүүхдэд мэдээлэл өгдөггүй	[ ]	[ ]	
13.	E-Mongolia болон Ekids аппликейшнээр дамжуулан орчны эрсдэл, зөрчлийг мэдээлэх боломжийг бүрдүүлж, хэрэглээг сурталчилдаггүй	[ ]	[ ]	

<u>Эрсдэлийн үнэлгээ:</u> Хүүхэд хамгааллын эрсдэлийн асуумжийн 1-2 асуултад “тийм” гэж хариулсан бол “эрсдэлтэй” гэж үзнэ.

Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Г. Баталгаажуулалт

ХЯНАЛТЫН ХОРООНЫ ҮНЭЛГЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ:	
Үнэлгээ хийсэн: *Хяналтын хорооны гишүүн:*	*Хүлээн зөвшөөрсөн:* *Байгууллагын албан тушаалтан:*
.... */овог нэр/*	.... */ албан тушаалын нэр, овог нэр/*
/гарын үсэг, тэмдэг/	*/ гарын үсэг/*

Хэрэв байгууллагын орчинд улсын байцаагч эрсдэлийн үнэлгээ хийсэн тохиолдолд “Улсын байцаагчийн баталгаажуулалт”-ын хэсгийг нөхөж бичнэ.

УЛСЫН БАЙЦААГЧИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ:	
Шалгалт хийсэн: *Улсын байцаагч:*	*Хүлээн зөвшөөрсөн:* *Байгууллагын албан тушаалтан:*
.... */овог нэр/*	.... */ албан тушаалын нэр, овог нэр/*
/гарын үсэг, тэмдэг/	*/ гарын үсэг/*

Арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаарх мэдээлэл

Оноо	Үнэлгээ	Тухайн аж ахуй нэгж, байгууллагад авах арга хэмжээ	Биелэлт
		Эрсдэлийг арилгах хугацаатай албан даалгавар	
		Зөвлөмж	

---oOo---